

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл ажиллагааны шинэчилсэн мэдээлэл – ДТ-9 цоонгийн туршилт**

Петро Матад компани нь Монгол орны зүүн хэсэгт байрлах, Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт ("БХГ" гэх) Матад ХХ талбай дахь **Давсан Толгой Төслийн** үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

ДТ-9 цооногийн туршилтын хөтөлбөр дуусч, агуулагч давхаргын шингэний олборлолтыг үр дүнтэйгээр туршиж чадсан ч бидний найдвар тавьж байсан интервалаас зөвхөн ус ялгарсан. Эндээс ялгарсан ус нь Цагаанцавын формациас илэрсэн ердийн уснаас ойролцоогоор тав дахин цэвэр байсан бөгөөд энэхүү ер бусын хүчин зүйл 2011 оны 08 дугаар сарын 22-ны өдөр мэдээлсэн туршилтын өмнөх каротажийн бичиглэлээр цэвэр тост үеийг алдаатай тооцоход хүргэсэн гэж үзэж байна.

ДТ-9 цооногийг 2011 оны 08 дугаар сарын 16-нд нийт гүнд буюу 1,766 метрт хүргэсэн. Өрөмдлөгийн явцад Доод Цагаанцавын дээд хэсэгт амьд тосны илэрц ажиглагдсан ба каротажийн бичиглэлээр 1,639-1,651 метрийн хооронд тооцоолсон тост үе тогтоогдсон. Энэ хэсгээс авсан дээж нь тосны толботой, мөн түүнчлэн хийн муруйн үзүүлэлт бага хэмжээгээр нэмэгдэж байсан.

Тухайн үед ДТ-9 цооногт хийсэн каротажийн бичиглэлийн үр дүнгээс нүүрсустөрөгчийн ханалтын үзүүлэлтийг тооцож гаргахдаа агуулагч давхаргын усны давсны агууламжийг 8,550 ppm (1 саяд эзлэх хувь)-р тооцсон. Давсны агууламжийн энэхүү үзүүлэлт нь ДТ-1 цооногийн анхны туршилтаар Цагаанцавын формациас ялгарсан усан дахь давсны агууламжийн тооцоолсон хэмжээтэй тохирч байсан. Энэхүү жишиг үзүүлэлт нь Давсан Толгойн хэмжээнд каротажийн бичиглэлийн үр дүнд үндэслэн Компанийн мэргэжилтнүүдийн тооцоолж, мөн хоёр бие даасан петрофизикийн мэргэжилтнээр баталгаажуулсан 4,700-14,000 ppm-ийн хооронд байгаа юм. XIX талбайд ялгасан Цагаанцавын агуулагч давхаргын усан дахь давсны агууламжийн хэмжээг СОКО Интернэшнл компани 2005 онд тогтоосон бөгөөд мөн дээрхи хэмжээнд байсан. ДТ-9 цооногийн формациас ялгарсан усан дахь давсны агууламж ойролцоогоор 1,700 ppm байсан. Ийнхүү Цагаанцавын агуулагч давхаргаас цэвэр ус илэрсэн нь туршилтын өмнөх каротажийн бичиглэлээр цэвэр тост үеийг алдаатай тооцсон үндсэн шалтгаан болж байна.

ДТ-9 цооногийн цементийн барьцалдалт сайтай, цементээр сайтар тусгаарлагдсан хэсгээс 14 цагийн турш шавхалт хийн нэг өдрийн шингэн олборлолтыг 200 баррелиар тогтоож, ДТ-9 цооногийн формацийн усыг ДТ-1 цооногийнхоос илүү бодитоор судалж чадсан. ДТ-1 цооногт ялгарсан ус нь ДТ-1 цооногийн шинэчилсэн мэдээлэлд дурдсан цементацийн үеийн механик хүндрэлээс шалтгаалж Цагаанцавын бус эх үүсвэрээс үүдэлтэй гэж үзэж байна.

ДТ-9 цооногийг хэтийн төлөв сайтай "Шороо" талбайд өрөмдөхөөр ялгасан хэсгүүд болон одоогоор Давсан Толгойд өрөмдөөд байгаа бусад талбайдаас тусгаарлагдсан, том хэмжээний хагарлын өргөгдлөөр хаагдсан хураагуур дээр байрлах бага хэмжээний атираат бүтэц дээр өрөмдсөн нь геологийн болон 3 хэмжээст сейсмийн үнэлгээгээр батлагдсан. Доод Цагаанцавын формацийн дээд хэсэгт орших тус атираат бүтэц нь хэмжээгээрээ бага боловч үр ашигтай хураагуурыг үүсгэсэн болохыг 1,597-1,601 метрт тогтоогдсон амьд тос харуулж байгаа хэдий ч тус интервал дахь агуулагч давхарга нь чанарын хувьд туршилт хийх хэмжээнд хүрээгүй.

Бид ДТ-9 цооногийн 1639-1651 метрт буюу илүү гүн, илүү зузаан, сүвэрхэг чанар сайтай интервалд туршилт хийхдээ шилжилт ихтэй хагарлын дагуу өргөгдсөн блокын ан цавжсан суурь чулуулгаар хаагдсан Цагаанцавт үндэслэсэн. Компани ДТ-9 цооногийн өрөмдлөгөөр ийм төрлийн хураагуурыг анх удаа судалж үзлээ. XIX талбайн судалгаа шинжилгээгээр ан

цавжсан суурь чулуулгаас ялгарсан ус нь маш цэвэр байгааг харуулсан. Тиймээс бид одоогоор ДТ-9 цооногоос илэрсэн усыг хагарлын дагуу өргөгдсөн блокын суурь чулуулгийн ан цавуудаас үүсэлтэй гэсэн дүгнэлтэнд хүрээд байна. Цаашид хагарлаар өргөгдсөн суурь чулуулагаар хаагдсан хураагуурт үндэслэн өрөмдлөгийн байрлалыг тодорхойлохдоо үүсч болзошгүй өндөр эрсдэлүүдийг тооцож байх болно.

Петро Матад Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал **Даглас МакГэй** хэлэхдээ “Хэдийгээр ДТ-9 цооногийн үр дүн хангалтгүй байгаа ч энэ нь Давсан Толгойд ялгаж, өрөмдсөн бусад бүтцүүдээс салангид бүтэцтэй, өөр төрлийн агуулагч давхаргатай болох нь тогтоогдсон. Тиймээс бид туршилтын муу үр дүнг Давсан Толгойд нийтэд нь хамааруулан сөргөөр үнэлэхгүй байна.”

“Цэвэр тост үеийн петрофизикийн тооцооны үр дүн алдаатай байсан нь харамсалтай ч цэвэр усны гэнэтийн илрэлийг харгалзан үзвэл энэ нь байж болох үндэслэлтэй зүйл юм.”

“Бид ДТ-9 цооногийн үр дүнгээр Давсан Толгойн бүрдлийн талаархи ойлголтоо нэмэгдүүлж, цаашид Давсан Толгойг манай хайгуул, үнэлгээний хувьд чухал төсөл болно гэдэгт найдаж байна.” гэлээ.

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группы үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100